



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 01 сарын 04 өдөр

Дугаар А/01

Сэвхүүл

Цэрэг, техникийн шинэчилсэн тоо бүртгэл  
явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Батлан хамгаалах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалт, аймгийн Засаг даргын 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/336 дугаар "Цэрэг, техникийн шинэчилсэн тоо бүртгэл явуулах тухай" захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Суманд 2017 оны цэрэг, техникийн шинэчилсэн тоо бүртгэлийг 2017 оны 01 дүгээр сарын 08-ны өдрөөс 2017 оны 01 дүгээр сарын 20-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Цэрэг, техникийн шинэчилсэн тоо бүртгэлийн ажлыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

КОМИССЫН ДАРГА: Х.МӨНХЖАРГАЛ - Засаг даргын Тамгын газрын дарга

ГИШҮҮД: Д.ОТГОНЖАРГАЛ - 1-р багийн Засаг дарга  
С.ОТГОНБААТАР - 2-р багийн Засаг дарга  
О.БОЛОРМАА-Нутгийн захиргаа, эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн  
Б.УУГАНБАЯР - Архив, бичиг хэргийн эрхлэгч

3. Цэрэг, техникийн шинэчилсэн тоо бүртгэлийн ажлыг тогтоосон өдөр, цагт зохион байгуулж, тайлан мэдээг хугацаанд нь гаргахыг комиссын дарга /Х.Мөнхжаргал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  В. БАТ-ЭРДЭНЭ